

Тав: Монгол Улсын геополитикийн хуучин статус өөрчлөгдөв. Монгол Улс хоёр их гүрний дунд хавчуулагдсан, далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алсмагдал, хөгжлийн тусламж гориллогч, буурай хөгжилтэй жижиг улс байсан бол эдүгээ аварга баавгай. аварга лууны дунд жороолж буй *pony* биш, харинч *galloper* буюу *шаандагст хүлэг* гэж хэлж болохоор, өөрөөр хэлбэл дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутаг, зах зээлд ойрохон орших болж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний хүчний үлэмж нөөцтэй нь тодорхой болсон нь олон улсын анхаарал, хөрш болон бусад их гүрнүүд, үндэстэн дамнасан нийгэмлэгүүдийн геополитик, гео-эдийн засгийн ашиг сонирхлыг эрхгүй татаж, энэ нь томоохон шинэ боломж, түүнчлэн томоохон шинэ эрсдлийг дагуулж байна.

Зургаа: Хятад, Америкийн худалдааны дайны үр дагавар Хятадын эдийн засгийн хөгжилд улмаар Монгол Улсын эдийн засаг, мөнгөний ханш, инфляцид сөрөг нөлөөтэй.

Долоо: Монгол Улс АДБХОБ-ны анхны үүсгэн байгуулагч 21 орон мөний хувьд гурван улсын авто замын коридор, эрчим хүчний супер сүлжээ, Замын-Үүд-Эрээний хамтын ажиллагааны бүсийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн зээл авах чиглэлээр ажиллах шаардлага байна.

ЦЭРГИЙН АЛБАНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ, ОНОЛЫН ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД

*В.Пүрэвбаасан-Доптоод хэргийн их сургуулийн Удирдлагын
академийн Хилийн албаны удирдлага, стратегийн
профессорын багийн дэд профессор, хурандаа*

Оршил

"Аюулгүй байдал" гэдэг ерөнхий ойлголтыг янз бүрээр тайлбарлаж байна. Энэ ойлголт тодорхой тохиолдолд субъектын аюулгүй байдлын өвөрмөц онцлогийг илэрхийлэхийн зэрэгцээ, олон салбарт хэрэглэж болох нийтлэг утга агуулагдаж байдаг.

Аюулгүй байдлын талаарх энэхүү ойлголтыг Я.Цэвэлийн тайлбар тольд: "аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй"¹, В.Далийн тайлбар тольд: "аюулгүй байдал гэдэг бол аюулгүй, бүрэн бүтэн байх, найдвартай, итгэлтэй байх"^{1 2} гэж тайлбарлажээ.

Аюулгүй байдлыг сахих үйл ажиллагаа нь нийгэмд зэвсэгт хүчин, хилийн цэрэг, цагдаа, хамгаалалтын болон онцгой байдлын албаны зэрэг хүчний байгууллагын бүтцийг буй болгон, улмаар бүхэлдээ дэлхий ертөнцийн нийт хүн амын аюулгүй байдлыг хангах үүрэгтэй НҮБ-ыг байгуулахад хүргэсэн байна.

Аюулгүй байдлын тогтолцоо "хэврэг" сул байх нь улс орон задрах, үндэстэн ястан устах, цус урсгасан зөрчил мөргөлдөөн үүсэх, материаллаг үнэт зүйлс эвдрэн сүйдэх зэрэг гай гамшигт хүргэдэг байна.

Сүүлийн үед аюулгүй байдал нь байгаль, нийгэм, техникийн салбар бүрийн онцгойг тохирсон аюулгүй байдлыг хангах тогтолцоо болон бие даасан шинжлэх ухаан болтлоо хөгжиж, аюул, занал, заналхийлэл, эрсдэл гэсэн үндсэн ухагдахуунуудыг бий болгож байна.

¹ Я.Цэвэл "Монгол хэлний товч тайлбар толь". УБ. 1966 он. 6Одахь тал

² Даль В.И. Толковый словарь русского языка. 2001 .с.44

Өнөө үеийн улс, үндэстэн бүхэнд даяаршлын аюулгүй байдал, дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдал, үндэстний аюулгүй байдал гэсэн 3 төвшинд аюулгүй байдлын асуудал түгээмэл яригдаж байна.

Аюулгүй байдлын ерөнхий онолыг бүрдүүлэгч шинжлэх ухаан нь гүн ухаан, нийгэм судлал, улс төр судлал, эдийн засгийн шинжлэх ухаан, мөргөлдөөн судлал, сэтгэл зүй, хууль зүйн шинжлэх ухаан, системийн судлал юм.

Аюулгүй байдлын тусгай онолын үүрэг бүхий шинжлэх ухаан нь анагаах ухаан, чичирхийлэл судлал, цацраг судлал, хөдөлмөрийн аюулгүй байдлын онол, найдвартай байдлын онол, эрсдэлийн онол, аюул сүйрлийн онол, цэргийн шинжлэх ухаан, түүний дотор цэргийн албаны аюулгүй байдал багтаж байна.

Үндсэн хэсэг

Цэргийн албаны аюулгүй байдал нь аливаа орны армийн хувьд цэрэг улс төрийн, нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудал юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллага, Хилийн цэргийн хувьд ч мөн адил бөгөөд бие бүрэлдэхүүний биеийн болон ёс суртахуун сэтгэл зүйн гэмтэл авах, амь үрэгдэх түвшинг бууруулах асуудал цэргийн албан хаагч цэргийн албан хаагч бүрийн өмнө тулгарч буй үндсэн асуудлуудын нэг юм. Төр энэ асуудлыг шийдэхгүйгээр цэргийн албаны цэргийн албаны нэр хүндийг дээшлүүлэх боломжгүй юм.

Монгол Улсын хуулийн дагуу цэргийн жинхэнэ албыг биеэр хааж байгаа иргэн, цэргийн сургууль, цугларалтад оролцож буй бэлтгэл үүрэгтнийг цэргийн алба хаагч гэнэ.¹

Цэргийн алба гэдэг нь иргэд Монгол Улсын Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллага болон бусад цэрэгт тодорхой хугацаанд Монгол Улсын хууль тогтоомжид заасан цэргийн үүргийг биелүүлэхэд оршдог төрийн албаны онцгой төрөл юм. Цэргийн алба нь онцлогоосоо хамааран өндөр эрсдэл бүхий салбар байсаар байсан байх ч болно.

Цэргийн ангийн алба хаагчдын өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаа Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүд, бусад баримт бичгийн зүйл заалтын дагуу хэрэгждэг. Тэдгээрт зааснаар цэргийн албаны аюулгүй байдал нь Цэргийн дотоод албаны дүрмээр мөрдөн хэрэгжиж байна.

Онолын хувьд цэргийн албаны аюулгүй байдал гэдэг нь цэргийн ангийн бие бүрэлдэхүүн, цэргийн алба хаагч нэг бүрийн алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, орон нутгийн иргэд, тэдний өмч, хүрээлэн буй орчныг өдөр тутмын үйл ажиллагааны явцад бий болсон цэргийн албаны аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалахад оршино.

Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах ажлыг цэргийн анги байгууллагын бүх албан тушаалтнууд хариуцсан чиглэлээрээ хэрэгжүүлнэ. Бие бүрэлдэхүүнтэй ажилладаг байгууллагууд цэргийн ангийн сахилга дэг журмын байдалд судалгаа хийж, түүнийг бэхжүүлэх арга хэмжээ боловсруулан, ажил зохион байгуулж аливаа зөрчилт үйл явдал гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Энэ тухай дотоод албаны дүрмийн 3 дугаар бүлэгт тодорхой тусгасан байна.

Ангийн штаб цэргийн албаны аюулгүй байдал, дэг журам хангах ажлын уялдааг хангах, цэргийн алба болон байлдааны бэлтгэлийн аюулгүй байдлыг хангах ажлыг хэрэгжүүлнэ. Салбарын дарга нар хуягттанкийн зэвсэглэл, автомашин техник ашиглах үед цэргийн алба хаагчид гэмтэж бэртэх, амь үрэгдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна, цэргийн эмнэлгийн алба цэргийн алба

хаагчдын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн урьдчилан сэргийлэх болон эмчилгээний цогц арга хэмжээг зохион байгуулна. Практик дээр энэ асуудал бие бүрэлдэхүүний байлдааны бэлтгэлийн явцад болон өдөр тутмын үйл ажиллагааны явцад шийдэгддэг.

Аюулгүй байдал гэдэг нь гадны болон дотоод аюул заналаас бие хүн, нийгэм, улс орны амин чухал эрх ашгийг хамгаалахыг хэлнэ.

Амин чухал эрх ашиг гэдэг нь бие хүн, нийгэм, улс орны дэвшин хөгжих боломж, оршин байх хэрэгцээг найдвартай хангахыг хэлнэ.

Аюулгүй байдлын үндсэн объектод бие хүний эрх, эрх чөлөө, нийгэм түүний материаллаг болон оюуны үнэт зүйлс, төр түүний үндсэн хуульт байгуулал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал хамаарна.

Аюулгүй байдлыг хангах үндсэн субъект нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын байгууллагуудаараа дамжуулан энэ салбарт үүргээ хэрэгжүүлж буй төр юм.

Аюулгүй байдалд учрах аюул занал гэдэг нь бие хүн, нийгэм, улс орны амин чухал эрх ашигт аюул учруулж буй нөхцөл, цогц хүчин зүйлс юм.

Дээр дурьдсанчлан цэргийн албаны аюулгүй байдал гэдэг нь цэргийн алба хаагчид, орон нутгийн иргэд, хүн ам, хүрээлэн буй орчныг цэргийн аливаа нэг үйл ажиллагааны улмаас бий болох аюулаас хамгаалах нөхцөлийг хангасан байдлыг хэлнэ.

Цэргийн алба хааж буй цэргийн алба хаагчийн аюулгүй байдал гэдэг нь цэргийн алба хаагч албан үүргээ биелүүлэх явцад хортой болон аюултай нөхцөл байдлаас хамгаалагдсан байхыг хэлнэ.

Цэргийн албаны аюултай хүчин зүйл гэдэг нь түүний нөлөөллийн улмаас цэргийн алба хаагчийн эрүүл мэнд эрс муудах, мөн түүнчлэн осол, гамшиг, зэвсэг, техникийн эвдрэлийн улмаас гэмтэл, бэртэлд хүргэж болзошгүй нөхцөлийг хэлнэ.

Цэргийн албаны хортой хүчин зүйл гэдэг нь тэрхүү аюултай хүчин зүйл тэдгээрийн нөлөөллийн улмаас мэргэжлийн өвчин тусах, ажиллах чадвар буурах, мөн зэвсэг болон цэргийн техник эвдрэх, гацахад хүргэж болзошгүй хүчин зүйлсийг хэлнэ. Нөлөөллийн түвшин, үргэлжлэх хугацаанаас хамаарч хортой хүчин зүйл аюултай хүчин зүйл болох боломжтой.

Цэргийн албаны аюулгүй байдлыг хангана гэдэг нь цэргийн алба хаагчийг тухайн аюул заналаас хамгаалах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлнэ гэсэн үг. Аливаа процесс нь зорилго, зорилт, хүрсэн үр дүнтэй байх бөгөөд тэдгээрийн хооронд харилцан хамаарал бүхий объект субьектууд оршино. Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах процессын зорилго нь бие бүрэлдэхүүнд нөлөөлөх тодорхой аюул заналын /харилцан хамаарал бүхий бүлэг аюултай болон хортой хүчин зүйл/ нөлөөллийг хамгийн бага түвшинд хүртэл бууруулах нөхцөлийг баталгаажуулах цэргийн албаны нөхцөл юм:

-Байлдааны жижүүр /алба/ харуулын болон дотоод алба гүйцэтгэх, цэргийн зэвсэг техникийн ашиглалт, засварлах, сэргээн засах ажил гүйцэтгэх, мөн түүнчлэн өдөр тутмын үйл ажиллагааны бусад үүргийг хэрэгжүүлэхдээ аюулгүй байдлыг хангах

-Цэргийн албаны аюулгүй байдлыг эмнэлгийн үйлчилгээний үүднээс хангах арга хэмжээ авч явуулах

-Хүрээлэн буй орчныг хамгаалах арга хэмжээ авч явуулах, галын аюулгүй байдлыг хангах г.м

Энэхүү процессын зорилгоос үүдэн цэргийн албаны аюулгүй байдлыг хангах

үндсэн зорилтуудыг дараахи байдлаар ангилж үзэж болно:

-Цэргийн алба хаагчдад албаны аюулгүй байдлын нөхцөлийг хангах хувийн хариуцлага бий болгох, амьдралын өөр өөр нөхцөлд аюулгүй ажиллах дадал чадварыг төлөвшүүлэх

-Сургалт, байлдааны бэлтгэл, зэвсэг техникийн ашиглалт, аж ахуй, барилгын ажлын явцад цэргийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх

-Зэвсэг, техник, галт хэрэгсэлтэй ажиллах, хичээл, буудлага, хээрийн сургалт, өдөр тутмын үйл ажиллагааны аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх төрөл бүрийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих арга хэмжээг хэрэгжүүлэх

-Цэргийн анги байгууллагын бүх албан тушаалтнууд эдгээр зорилтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

-Цэргийн албаны аюулгүй байдлыг эрх зүй, нийгэм эдийн засаг, техник зохион байгуулалтын, ёс суртахуун сэтгэл зүй, эрүүл мэндийн, ус цаг уурын хангалт, мөн түүнчлэн цэргийн үйл ажиллагааны экологийн аюулгүй байдал гэх мэт чиглэлээр хангана. Ийнхүү цэргийн албаны аюулгүй байдлыг хангах ерөнхий нөхцөл нь: цэргийн сахилга дэг журмыг мөрдөх, цэргийн алба хаагчийн ёс суртахуун, сэтгэл зүйн таатай нөхцөл, эрүүл мэндийн байдлыг хангах, Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүдийн Дотоод албаны дүрмээр тодорхойлсон журмыг мөрдөх, Монгол Улсын хууль, бусад эрх зүйн хэм хэмжээний актуудын шаардлагад нийцүүлэн цэргийн алба хаагчийн нийгмийн хамгааллыг хангах, цэргийн ангийн эрүүл ахуй, халдварын таатай нөхцөлийг хангах зэрэг юм.

Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах процессын бүтцээс үүдэн цэргийн албаны аюулгүй байдлын ерөнхий болон тусгай шаардлагыг үндэслэн зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагын үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэх, тавьсан зорилгодоо хүрэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд анги салбарын өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд цэргийн алба хаагч нэг бүр цэргийн албаны аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

Цэргийн алба хаагч амь үрэгдэх, гэмтэл бэртэл авахаас урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, орон нутгийн иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөд хохирол учрахаас урьдчилан сэргийлэх, цэргийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны явцад үүсэн бий болсон аюул заналаас хүрэлэн буй орчныг хамгаалах, байгаль орчныг зүй зохистой ашиглах үндсэн арга хэмжээг Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүдийн дотоод албаны дүрэмд тодорхойлсон байдаг. Үүнд:

- бие бүрэлдэхүүний ёс суртахуун, сэтгэл зүйн байдлыг судалсны үндсэн дээр сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах,

- цэргийн хамт олны дунд сэтгэл зүй, ёс суртахууны таатай нөхцлийг бий болгох,

- цэргийн алба хаагчийн хоорондын харилцаанд дүрэмд заасны эсрэг зөрчил гаргахгүй байх нөхцлийг бий болгох,

- хууль эрх зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зэрэг орно.

Бие бүрэлдэхүүнийг цэргийн албаны аюулгүй байдалд тавигдах шаардлагуудыг урьдчилан судуулж, өдөр тутмын үйл ажиллагааны арга хэмжээг биелүүлэхэд тогтмол бэлэн байлгах нь чухал.

Цэргийн дүрмийн дагуу цэргийн алба хаагчийг амь үрэгдэх, гэмтэл бэртэл авахаас урьдчилан сэргийлэхийн тулд амь нас, эрүүл мэндэд өндөр эрсдэлтэй албан тушаал дээр цэргийн алба гүйцэтгэж буй цэргийн алба хаагчдын дунд эхний

ээлжинд сургалт явуулах нь зүйтэй. Үүний тулд албан үүргээ гүйцэтгэх явцад нь цэргийн албаны аюулгүй байдлын шаардлагыг биелүүлэх чиглэлээр онолын мэдлэг практик дадлыг нь үе шатгайгаар шалгаж энэхүү шалгалтанд сэтгэл зүйч эмч нарыг татан оролцуулна.

Бие бүрэлдэхүүний дунд өндөр сонор сэрэмжтэй байх, хоногийн харуул манааны үүргийг дүрмийн дагуу биелүүлэх, алан хядлагын эсрэг арга хэмжээ авах, галын аюулгүй байдлыг хангах, аврах ажиллагаанд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

Цэргийн албаны аюулгүй байдлын шаардлагыг бие бүрэлдэхүүн хэрэгжүүлж буй байдалд байнга хяналт тавих шаардлагатай.

Орон нутгийн иргэд хүн амын амь нас эрүүл мэнд, өмч хөрөнгөд хор хохирол учрахаас урьдчилан сэргийлэх үндсэн арга хэмжээнд:

- Холбооны хууль, цэргийн дүрэм, зохих удирдамж зааврын дагуу боловсруулсан иргэд, иргэний объектуудын хувьд цэргийн зэвсэг техник хэрэглэхгүй байх арга хэмжээ авах, цэргийн аюултай объектуудыг суурин газрын эрүүл ахуйн хувьд хамгаалалттай бүсээ гадна байрлуулах,

- Цэргийн алба хаагч болон орон нутгийн иргэдийн хооронд сайн харилцаа тогтоох зорилгоор ангийн командлал, орон нутгийн өөрөө удирдах байгууллагатай хамтран ажиллах,

- Ангийн байрлалын бүсэд тогтоосон хязгаарлах арга хэмжээний талаар нутгийн өөрөө удирдах байгууллагатай харилцан тохиролцож иргэдэд мэдээлэл хүргэх гэх мэт.

Цэргийн өдөр тутмын үйл ажиллагааны явцад үүсэн бий болсон аюул заналаас хүрээлэн буй орчныг хамгаалах, байгаль орчныг зүй зохистой ашиглах үндсэн арга хэмжээнд:

Монгол Улсын байгаль орчныг хамгаалах тухай эрх зүйн хэм хэмжээний актууд, хуулиудыг бие бүрэлдэхүүнд судлуулж экологийн хүмүүжил олгох, анги байгууллаагын өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ болон ангийн байрлалын бүсэд хүрээлэн буй орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх, анги байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад болон осол аваарын улмаас бохирдсон хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх, байгаль орчныг зүй зохистой ашиглах (байгалийн нөөцөд хэмнэлттэй хандах, хаягдалгүй, хаягдал багатай технологи нэвтрүүлэх, усны нөөцийг зүй зохистой ашиглах, газрыг нөхөн сэргээх гэх мэт).

Дээр дурьдсан арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх үедээ онцгой байдлаас бусад нөхцөлд иргэний объектуудыг байрлуулах, барьж байгуулах, ашиглахдаа зайлшгүй мөрдвөл зохих хүрээлэн буй орчныг хамгаалах тухай Монгол Улсын хууль тогтоомжийн шаардлагыг харгалзан эдгээр шаардлагыг биелүүлэхэд зөрчилдөж буй цэргийн объект, зэвсэг, техниктэй холбоотойгоор зохих арга хэмжээ авах нь зүйтэй.

Онолын хувьд цэргийн албаны аюулгүй байдлын арга хэмжээ хэрэгжүүлсний үр дүн өөр өөр байж болно. Түүнийг цэргийн албаны аюулгүй байдлын түвшингээр (маш өндөр, өндөр, дундаж, доод, аюултай) тодорхойлно.

Цэргийн албаны аюулгүй байдлыг үр дүнтэй зохион байгуулахад цэргийн албан хаагчдын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн албаны аюулгүй байдлын нөхцөл тодорхой хувиар нөлөөлдөг. Цэргийн өдөр тутмын үйл ажиллагааны гол үндсэн нөхилийг цэргийн албаны аюулгүй байдлын ерөнхий нөхцөл, цэргийн албан үүрэг гүйцэтгэх үеийн цэргийн алба хаагчийн аюулгүй байдлын нөхцөл, цэргийн үйл

ажиллагаа хэрэгжүүлэх явцад хүрээлэн буй орчинд хор хохирол учрахаас урьдчилан сэргийлэх нөхцөл, орон нутгийн иргэдийн аюулгүй байдлын нөхцөл гэж ангилж үзэж болно.

Цэргийн албаны аюулгүй байдлын ерөнхий нөхцөлд:

Цэргийн дүрэмд заасан шаардлагын дагуу зохион байгуулж буй анги салбарын сахилга дэг журам, зэвсэг техник галт хэрэгсэл тэсрэх бодисын хадгалалт хамгаалалт, цөмийн радиацийн, химийн, биологийн аюулгүй байдал, цэргийн аюултай объектуудын галын аюулгүй байдал, цэргийн алба хаагчийн эрүүл ахуй халдварын аюулгүй байдал зэрэг орно.

Цэргийн албан үүргээ биелүүлэх явцад нь цэргийн алба хаагчийн аюулгүй байдлыг хангах нөхцөлд:

- Цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, санхүү материаллаг хэрэгслийн хангалт, үйлчилгээ

- Бие бүрэлдэхүүний ёс суртахуун сэтгэл зүйн таатай байдал

- Цэргийн албан хаагчдын эрүүл мэндийг сайжруулах, цэргийн албаны аюулгүй байдлыг хангахад тэднийг бэлтгэх

- Цэргийн зэвсэг техникийн ашиглалтын аюулгүй байдал

- Цэргийн объектуудын галын аюулгүй байдал, хамгаалалт

- Цэргийн хотхон объектуудад терроризмын халдлага, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг ажил хамаардаг

Энхийн цагт цэргийн албаны аюулгүй байдлын дөрвөн үндсэн нөхцөлийг ангилж үздэг. Үүнд:

- Цэргийн өндөр сахилга бат

- Цэргийн албан хаагчдын хооронд цэргийн дүрэмд заасан зөрчил гаргуулахгүй байх

- Амиа егүүтгэхээс урьдчилан сэргийлэх

- Зэвсэг техник ашиглах, аж ахуй барилгын үйл ажиллагаа явуулахдаа аюулгүй байдлыг мөрдөж ажиллах

Цэргийн албаны аюулгүй байдлын түвшин өндөр байгаа нь дээр дурьдсан нөхцлүүд хангагдаж байгааг илтгэнэ. Цэргийн анги байгууллагад цэргийн албаны аюулгүй байдал хангагдаж буйг бодитоор үнэлэх нь чухал зорилт юм.

Цэргийн албаны аюулгүй байдал гэдэг нь анги салбарт тодорхой хугацаанд амь үрэгдсэн, гэмтэл бэртэл авсан, өвчилсөн цэргийн албан хаагчдын үнэмлэхүй тоо юм.

Цэргийн албаны аюулгүй байдлын түвшин гэдэг нь цэргийн алба хаагчийн тоонд албаны аюулгүй байдлыг харьцуулан гаргаж авсан харьцангуй хэмжигдэхүүн юм. Цэргийн албаны аюулгүй байдлын хэд хэдэн түвшинг ангилж үздэг. Үүнд:

- маш өндөр,

- өндөр,

- дундаж,

- доод,

- аюултай түвшин

Маш өндөр түвшин гэдэг нь цэргийн анги салбарт цэргийн албан хаагчид амь үрэгдэх, гэмтэж бэртэх, өвчлөхтэй холбоотой ямар нэг тохиолдол гараагүй байдлыг хэлнэ. Цэргийн алба хаагчид гэмтэж бэртэх, өвчлөх ерөнхий тоо нь ийрт бие бүрэлдэхүүний 20%-иас хэтрэх ёсгүй гэх мэт.

Дүгнэлт

Цэргийн албаны аюулгүй байдлын түвшинг тодорхойлсноор цэргийн анги байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд албаны аюулгүй байдал хангагдаж буй эсэхийг хэлж болно. Аюулгүй байдлын дүрэм журам ямар нэг нөхцөл байдлаас үл хамааран ямар ч нөхцөлд биелэгдэж мөрдөгдөж байх ёстой. Ийнхүү орчин үед цэргийн албаны аюулгүй байдлыг хангах нь цэргийн анги байгууллагын байлдааны бэлэн байдлын гол хүчин зүйл болоод байна. Цэргийн албаны аюулгүй байдлыг хангасны үр дүн нь албан тушаалтнуудын сургалт, хүмүүжилд чиглэсэн зорилго бүхий үйл ажиллагаа, мөн сөрөг хүчин зүйлийн нөлөөллийг саармагжуулах, цэргийн анги байгууллагын үйл ажиллагааны аюулгүй нөхцөлийг бий болгох, цэргийн албаны аюулгүй байдлын төлөө цэргийн алба хаагч бүр хариуцлагатай байхаас хамаарч байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ХОРИГ БА МОНГОЛ УЛС: СОРИЛТ, ШИЙДЭЛ

*Д. Ула.мбаяр-Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн
Олон улсын харилцаа, нийгэм
судлалын сургуулийн захирал*

*Т. Уянгаа-Монгол-Европын Холбооны түншлэлийг
дэмжих пөвийн төслийн шинжээч*

Удиртгал

Дипломат ажиллагаанд улс төрийн бодлого тэргүүлэх шинжтэй боловч, эдийн засгийн чиглэл тодорхойлох шинжтэй байх нь түүхэнд олонтой байсан бөгөөд даяаршлын эрин үед хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт тавигдаж, түүний ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэж байгаа нь бидний нүдний өмнө илт болов.

Дэлхийн II дайны дараа АНУ-ын Засгийн газар дипломат ажиллагааг «худалдаажуулах» эрчимтэй арга хэмжээ авснаар «*trade diplomacy*» гэсэн нэр томьёо гарчээ. Энэ нь эдийн засгийн дипломат ажиллагааны нэг хэсэг юм. Мөн «*commercial diplomacy*» гэсэн нэр гарсан нь цэвэр бизнес, арилжаатай холбоотойгоор Үндэстэн дамнасан корпорациудын дэлхий даяар явуулж буй олон улсын маркетингийн бодлоготой холбоотой гэж хэлж болно.

Орчин үеийн эдийн засгийн дипломат ажиллагааны үндэс суурь чухамхүү АНУ-д тавигджээ. АНУ-ын эдийн засгийн дипломат ажиллагааны үндсэн зорилго нь *нэгд*. Дэлхийн эдийн засагтай нягт холбогдсон үндэсний эдийн засгийг макро, микро түвшинд зөв менежментээр удирдах, *хоёрт*. Америкийн үндэсний эрхэм дээд эрх ашгийг удирдлага болгон глобал эдийн засгийн харилцаа, дэлхийн зах зээлийг зөв менежментээр удирдах, *гурв*. АНУ-ын гадаад дахь худалдаа, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийг тууштай хамгаалах, *дөрөвт*. Олон улсын эдийн засгийн харилцаан дахь тарифын болон тарифын бус саад тотгорыг арилгаж, худалдаа, хөрөнгө оруулалтыг хөнгөвчлөх, *тавд*. Олон улсын аюулгүй байдлыг эдийн засгийн аргаар хангах, *зургаад*. Дэлхий дахинд АНУ-ын талаар зөв имиж бүрдүүлэх, *долоод*. Хүний эрх, ардчилал, сайн засаглал, зах зээлийн эдийн засгийг тууштай баримтлагч, олон улсын терроризмын эсрэг тэмцэгч улс орон, Засгийн газрыг бүх талаар дэмжих (жишээ нь: АНУ-ын Мянганы сорилтын сангийн буцалтгүй тусламж), *наймд*, Олон улсын энхтайван, аюулгүй байдалд заналхийлж буй болон үл ташаагч орнуудын (цөмийн болон баллистик пуужингийн хөтөлбөр хэрэгжүүлж буй, олон улсын эрхзүйн зарчим, хэм хэмжээг ноцтой зөрчсөн, хүний эрх, ардчилал, сайн засаглал